



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/844


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үндэсний бөхийг хөгжүүлэх, хүүхэд багачуудыг үндэсний бөхөөр хичээллэх боломж олгох зорилгоор бага насны хүүхдийн зодог шуудаг, бөхийн малгай, гутал худалдан авах зардлыг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 7 250 000 төгрөг /Долоон сая хоёр зуун тавин мянган/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 23-ны өдрийн  
А/844 дүгээр захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1.	Бага насны хүүхдийн зодог шуудаг	ш	58	40 000	2 320,0
2.	Үндэсний бөхийн хүүхдийн малгай	ш	58	25 000	1 450,0
3.	Хүүхдийн бөхийн гутал	ш	58	60 000	3 480,0
ДҮН					7 250,0

-oOo-